

**Японы Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь”
төслийн үр дүнгийн үнэлгээ хийх ажлын удирдамж**

Товчилсон үгийн жагсаалт.....	2
3. Бүрэлдэхүүн	6
Техник-арга зүй	7
Бусад тусгай шаардлагууд.....	7
Төслийн менежмент	7
4. Судалгааны багийн бүрэлдэхүүн	8
Судалгааны багийн ахлагч	8
Судлаач 1: Судалгааны менежер:.....	9
Судлаач 2: Дата, мэдээлэл цуглуулах мэргэжилтэн:	9
Богино-хугацааны судлаач 1: Орон нутагт нутагт мэдээлэл цуглуулах багийн ахлагч:	10
Богино хугацааны судлаач 2: Орон нутагт мэдээлэл цуглуулагчид	10
5. Төлбөр болон бусад холбогдох зардлууд	11
7. Сонгон шалгаруулалтад тавигдах шаардлага	11

Товчилсон үгийн жагсаалт

БЯ	Боловсролын яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ХГБХХЕГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ОСАЗ	Оролцоонд суурилсан арга зүй
ЯХИС	Японы Хүүхдийг Ивээх Сан

1. Агуулга

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхдийн эрхийг хангах, түүнийг хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, шашны бус, олон улсын төрийн бус байгууллага юм. Бид хүүхдийн амьдралд урт хугацааны, тогтвортой өөрчлөлтийг бий болгох зарчмыг баримтлан, тулгамдаж буй асуудлуудад бодитой, системтэй шийдлийг олох аргазүйг эрхэмлэн ажилладаг. Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Хөтөлбөрийн газар нь Японы Хүүхдийг Ивээх Сангийн бүрэлдэхүүнд багтдаг ба боловсрол, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал, хүүхдийн ядуурал болон хүмүүнлэгийн тусламж, эрүүл мэндийн чиглэлд төсөл, хөтөлбөрүүдээрээ дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр нь **“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь”** төслийг нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүд, Говь-Алтай, Ховд аймгуудын ерөнхий боловсролын нийт 14 сургууль, 14 хамтарсан багуудыг түшиглэн 2023 оны 01 дүгээр сараас 2025 оны 12 дугаар сарын 31 -нийг дуустал нийт 3 жилийн хугацаанд хэрэгжүүлж байна.

Төсөл нь Хүүхэд хамгааллын системчилсэн механизмыг төслийн зорилтот газруудад хэрэгжүүлснээр Хамтарсан баг, сургууль, дотуур байр, эцэг эх/асран хамгаалагчид болон хүүхдүүдийг боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын асуудлаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах загвартай болгох зорилготой юм.

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл нь дараах 3 үндсэн үр дүнд хүрэхээр чиглэн ажилласан. Эдгээр нь:

1. Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах зорилгоор сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын механизмыг бүрдүүлэн, бэхжүүлэх.
2. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авахад сургууль, орон нутаг, үндэсний түвшний сайн зохицуулалт, хяналтын тогтолцоо бүхий Хүүхэд хамгааллын механизмуудыг бий болгоход дэмжлэг үзүүлэх.
3. Хүүхэд хамгааллын асуудлыг даван туулах хүүхдүүдийн чадварыг нэмэгдүүлэх: Хүүхдүүд өөрсдийн хамгаалагдах эрхийн талаар мэдлэгтэй болж, аливаа асуудалтай тулгарсан үед өөрийгөө халамжлах ба үе тэнгийнхэндээ сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үр чадварт суралцах Түүнчлэн сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын асуудлаар хүүхдийн дуу хоолойг холбогдох томоохон байгууллагуудад хүргэж, холбогдох бодлого журмуудад тусгах

ХИС нь төсөл эхлэх үед **“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь”** (2023-2025) төслийн гарааны нөхцөл байдлыг тодорхойлох суурь судалгааг хийсэн бөгөөд, мөн төслийн эцсийн шатанд д төслийн хэрэгжилт, хүрсэн үр дүн, төслийн шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг хэмжих зорилгоор төслийн үр дүнгийн үнэлгээг хийхээр төслийн үндсэн бичиг баримтад тусгасан болно.

Төслийн үр дүнгийн үнэлгээний зорилго: Хамтарсан баг, сургууль, дотуур байр, эцэг эх/асран хамгаалагчид болон хүүхдүүдэд боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын асуудлаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах загварыг бий болгох зорилго бүхий **“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь”** төслийн эцсийн шатны нөхцөл байдлыг тодорхойлно. Нарийвчилбал, төслийн үндсэн бичиг баримтад тусгагдсан шалгуур

үзүүлэлтүүдийн биелэлтийг хэмжсэнээр гарааны нөхцөл байдал буюу, холбогдох үзүүлэлтүүдийн суурь судалгаагаар гарсан үр дүн, суурь үзүүлэлтүүдтэй харьцуулна.

Төслийн үр дүнгийн үнэлгээний зорилгын хүрээнд:

- Зорилтот орон нутаг, сургууль, Хамтарсан баг бүрийн холбогдох тоон болон чанарын судалгааны мэдээллээр төслийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг хэмжих;
- Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ үзүүлэхэд оролцогч талуудын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын чадавхын өнөөгийн байдлыг тодорхойлон, суурь судалгааны үзүүлэлттэй харьцуулан дүн шинжилгээ хийх;
- Хүүхэд хамгааллын чиглэлээр төрөөс баталсан бодлого, дүрэм, журмыг зорилтот орон нутаг, сургуулиудын хэрэгжүүлж буй өнөөгийн нөхцөл байдал, зохион байгуулалтад анализ хийн, дүн шинжилгээ хийх;
- Хүүхдийг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид сурган, чиглүүлэх, хүмүүжүүлэх талаарх сургуулийн багш ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчдын өнөөгийн ойлголт, мэдлэг, хэрэглээг судлан тодорхойлох, төсөл эхлэхээс өмнөх байдалтай харьцуулсан дүн шинжилгээ хийх;
- Орон нутаг, сургууль дахь хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэх төсөв боловсруулах үйл явцад оролцогч талуудын оролцоог тодорхойлон төсвийн дүн шинжилгээ хийх;
- Хүүхдийн эрх, хамгааллын талаарх хүүхдүүдийн ойлголт, мэдлэг, үе тэнгийнхэн бие биеэ дэмжин хамгаалах, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлд орсон тохиолдолд хэнд, хаана хандахаа мэддэг эсэхийг тодорхойлох,
- Сургуулийн ажилтнуудын зүгээс хүүхдийн оролцооны бүлгийг дэмжин ажиллах одоогийн мэдлэг, ойлголт, чадвар ямар байгааг судлах, төсөл эхлэхээс өмнөх байдалтай харьцуулсан дүн шинжилгээ хийх;
- Өсвөр насны охид хөвгүүдийн өөртөө тулгарсан аливаа бэрхшээлийг хэрхэн даван туулж байгаа нөхцөл байдал, мөн бусдад өөрийгөө нээлттэй зөвөөр илэрхийлэх, бусдыг ойлгон мэдэрч туслах, бусадтай хүндэтгэлтэй харьцах зэрэг нийгмийн үр чадварууд нь зорилтот орон нутаг сургуулиудад ямар түвшинд байгааг судлах, төсөл эхлэхээс өмнөх байдалтай харьцуулсан дүн шинжилгээ хийх;
- Хамтарсан багуудын зүгээс сургуультай хүүхэд хамгааллын чиглэлээр хамтран ажиллаж буй байдал болон хүүхэд хамгааллын үйлчилгээ, кейс менежментийн үйлчилгээг багаараа үзүүлж буй байдлыг үнэлэх
- Төслийн үр дүн, хэрэгжилт хүүхдүүдэд бодитоор хэрхэн хүрснийг тодорхойлох

Төслийн үр дүнгийн үнэлгээнд төсөл хэрэгжсэн 28 нэгжийг (сургууль, Хамтарсан багууд оролцуулан) бүрэн хамруулахаас гадна холбогдох бодлогын баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийнэ.

Судалгааны аргачлал:

Төслийн үр дүнгийн үнэлгээг хийхдээ тухайн төслийн суурь судалгааны үед боловсруулсан мэдээлэл цуглуулах арга зүй, аргачлалыг ашиглана. Шаардлагатай бол нэмэлтээр асуумж, арга зүйг боловсруулна. Мөн тоон ба чанарын судалгааны аргуудыг хослуулан ашиглана. Мэдээлэл цуглуулах үндсэн аргууд:

- Асуулга

- Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага
- Ажиглалтын арга
- Хоёрдогч мэдээллийн эх үүсвэрийн дүн шинжилгээ
- Төсөлд зориулан боловсруулагдсан бусад мэдээлэл цуглуулах арга

Судалгааны явцад анхдагч болон хоёрдогч мэдээллийн эх үүсвэрээс цуглуулсан мэдээллийн үнэн бодит байдал, баталгаажуулалт болон харилцан уялдааг анхаарч ажиллана.

Судалгааны хамрах хүрээ:

- Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэргэжилтнүүд
- Боловсролын ерөнхий газрын мэргэжилтнүүд (Нийслэл, аймаг, дүүргүүдийн боловсролын газар, хэлтсүүд)
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын мэргэжилтнүүд (Нийслэл, аймаг, дүүргүүд)
- Төсөл хэрэгжсэн сургуулиудын эцэг эхийн зөвлөлийн гишүүд, сум, баг, хороодын иргэд, эцэг эх, хүүхдүүд

Дараах хүснэгтээс төслийн нэгжүүдийн талаарх мэдээллийг харна уу.

№	Төсөл хэрэгжсэн орон нутгууд	Төсөл хэрэгжсэн нэгжүүд
1	Говь- Алтай аймаг	-Аймгийн төвийн буюу Есөнбулаг сумын 4 дүгээр сургууль, Баянхайрхан багийн Хамтарсан баг -Дарив сумын ерөнхий боловсролын сургууль, Дарив сумын Хамтарсан баг
2	Ховд аймаг	-Аймгийн төвийн буюу Жаргалан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Жаргалант багийн Хамтарсан баг - Дарви сумын ерөнхий боловсролын сургууль, Дарви сумын Хамтарсан баг
3	Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүд	Дүүрэг тус бүрээс төсөлд сонгогдсон 2 сургууль, 2 Хамтарсан баг

2. Судалгааны багийн хийж гүйцэтгэх ажил:

Судалгааг багаар хийж гүйцэтгэх ба Хүүхдийн Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрийн төслийн багтай хамтран ажиллана. Судалгааны баг нь дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Төслийн зорилго болон зорилтууд, үйл ажиллагаануудыг танилцуулах 1 өдрийн уулзалтад оролцоно. Судалгааны төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай үндэслэлийг тайлбарласан байна.
2. Судалгааны аргазүй, аргачлалыг дахин нягтлах, түүврийг тооцох, шаардлагатай үндэслэлийг тайлбарласан байна.
3. Судалгааны аргазүй, аргачлал нь төслийн хэрэгжилтийн үр дүнгийн холбогдох мэдээллийг цуглуулахад тохиромжтой эсэхийг хамгийн багадаа 2 бүлэгт туршиж, үр дүнд нь үндэслэн аргачлалыг эцэслэн боловсруулна.

4. Судалгааны нэгдсэн ойлголт болон арга зүйн талаар ЯХИС-тай ярилцах; үр дүнгийн харгалзах шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд судалгааны хэрэглэгдэхүүнүүдийг бэлтгэх.
5. Судалгааны үйл явц, зохион байгуулалт, тухайн орон нутаг болон сонгогдсон ажилтан, өрх гэр бүл, хүүхдүүдээс судалгаа авахдаа таниулсан зөвшөөрөл заавал авах зэргийг хариуцан удирдаж явуулна.
6. Цуглуулсан мэдээллийн чанар, найдвартай байдал, зохион байгуулалтыг хариуцна.
7. Мэдээллийг цуглуулж, системд оруулан, дүн шинжилгээ хийнэ. Судалгааны тайланг англи, монгол хэлээр бэлтгэнэ.
8. Судалгааны үр дүнг хураангуйлсан хэлбэрээр бэлтгэн (Power Point Presentation) төслийн баг хамт олон, хамтрагчид болон бусад оролцогчдод танилцуулна.

Судалгааны багаас хүлээгдэж буй гүйцэтгэлүүд:

- Үр дүнгийн үнэлгээний тайлан нь олон улсын стандартын дагуу бичигдсэн байх бөгөөд англи, монгол хэл дээр тус бүр **40-50** хуудсанд (хавсралтууд орохгүйгээр) багтсан байна. Судалгааны баг нь эцсийн тайланг төслийн багт файлаар хүлээлгэн өгнө.
- Судалгааны үр дүнгийн график мэдээлэл бүхий хураангуйлсан хэлбэрийг (Power Point Presentation) англи, монгол хэл дээр бэлтгэн төслийн багт файлаар хүлээлгэн өгнө.
- Судалгааны хүрээнд цуглуулсан бүх мэдээллийг (зураг, хүснэгт, SPSS дата г.м) төслийн багт хүлээлгэн өгнө.
- Судалгааны бусад материал, мэдээллийг (судалгаанд оролцогчдын нэрс гэх мэт) хавсралтаар төслийн багт хүлээлгэн өгнө.

Судалгаа хийж гүйцэтгэх төлөвлөгөө:

Гэрээний хугацаанд тодорхой үе шат бүхий дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

№	Хийгдэх ажлууд	Хугацаа
1	Судалгааны ажлын төлөвлөгөө, стратеги боловсруулах, судалгааны арга зүйг хянах, сайжруулах	8-р сарын 11-15 өдрүүд
2	Туршилтын мэдээлэл цуглуулах	8-р сарын 18-20 өдрүүд
3	Судалгааны арга зүйг эцэслэн батлах	8-р сарын 20-25 өдрүүд
4	Судалгааны агуулгыг багтаасан эхлэлийн тайлан өгөх	8-р сарын 26-29 өдрүүд
5	Мэдээлэл цуглуулах дүн шинжилгээ хийх	9-р сарын 01-нээс 09-р сарын 21-ний өдөр
6	Судалгааны гүйцэтгэл, эцсийн тайлангийн анхны хувилбарыг монгол хэл дээр боловсруулан төслийн багт илгээх	9-р сарын 22-ноос 10-р сарын 15-ны өдөр
7	Тайланг хянах, санал өгөх, засварлах	10-р сарын 22-30 өдрүүд
8	Тайланг англи хэл рүү орчуулах	11-р сарын 01-10 өдрүүд
9	Орчуулсан тайланг хянах, засварлах	11-р сарын 15-24 өдрүүдэд
10	Судалгааны үр дүнг танилцуулах	11-р сарын 27-29 өдрүүдэд
11	Судалгааны тайланг эцэслэх	11-р сарын 29-30 өдрүүдэд

Үнэлгээний ажлыг хийж дуусгах хугацаа: **2025 оны 08 дугаар сараас 2025 оны 11 дүгээр сарын 30**

3. Бүрэлдэхүүн

Тендерт оролцогч нь 1-р бүлэгт тодорхойлсон зорилтуудыг хэрэгжүүлэх боломж, цаашилбал техник-арга зүйн шаардлагыг хэрэгжүүлэх боломж бий эсэхийг нотлох шаардлагатай. Мөн

тендерт оролцогч нь хийж гүйцэтгэх ажлынхаа төслийн менежментийн системийг тодорхойлсон байна.

Техник-арга зүй

Стратеги: Тендерт оролцогч нь энэхүү судалгааны ажлын зорилго болон гүйцэтгэх ажилтай сайтар танилцсан байх шаардлагатай. (Бүлэг 1 -ийг үзнэ үү). Түүнчлэн хийж гүйцэтгэх ажил үйлчилгээний төлөвлөгөө, стратегиа боловсруулж танилцуулна. (2-р бүлгийг үзнэ үү).

Тендерт оролцогч нь ажил, үйлчилгээ үзүүлэх **хамтарч** ажиллах хүмүүсийн үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байна.

Тендерт оролцогч нь төслийн хамтрагч, түншүүдтэй хийх уулзалт, судалгааны үйл явцыг **удирдан зохион байгуулах арга барил, түршлагатай** байна. Мөн судалгаанаас гарсан үр дүнд үндэслэн, төслийн цаашдын төлөвлөлт ба хэрэгжилт, түүнчлэн боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын онцлогт тулгуурласан бодлогын зөвлөмжийг гаргахуйц чадамжтай байна.

Тендерт оролцогч нь хариуцан хэрэгжүүлж буй үйлчилгээнийхээ гол **процессыг** тодорхойлж, 2-р бүлэгт заасны дагуу ажил үйлчилгээг хэрэгжүүлэх хуваарь гаргах шаардлагатай. Тухайлбал хийж гүйцэтгэх ажил, үйлчилгээний үе шатуудыг тодорхойлж, 2-р бүлэгт заасны дагуу судлаачдын багийн гишүүдийн хариуцаж хийх ажлыг тодорхой болгосон байна.

Мэдээлэл цуглуулахын тулд чанарын болон тоон судалгааны арга зүйг холимог байдлаар зэрэгцүүлэн эсвэл дараалан хийхийг санал болгож байна.

Чанарын судалгааг оролцооны аргыг ашиглан хийнэ. (Ганцаарчилсан болон ФБЯ, Оролцоонд Суурилсан Арга Зүй (ОСАЗ)). Зорилтот түүврийг боломжит цаг хугацаа, хүн хүчний нөөцөд тулгуурлан хийх шаардлагатай.

Тоон мэдээллийг цуглуулахын тулд найдвартай, алдааны зөрүүг тооцох боломжтой, статистикийн ач холбогдолтой, судалгааны өгөгдөлд чанартай хяналт тавих сайн түүвэрлэлтийн аргуудыг боловсруулах шаардлагатай.

Орон нутагт судалгаа хийх судлаач, багийн ахлагч нар мэдээлэл цуглуулахад бэлтгэгдсэн байх ёстой. Тухайлбал асуумжуудыг тест хийх, шаардлагатай бол ЯХИС-ийн төслийн баг болон хамтрагч нарын санал зөвлөмжийг оруулах, засах; ярилцлага хийх, мэдээлэл оруулах дадлага хийх зэрэг болно.

Бусад тусгай шаардлагууд

Орон нутагт судалгааны ажил хийх, ярилцлага хийхэд жендерийн тэгш байдлыг хангах түүнчлэн үнэлгээний багийн жендерийн бүрэлдэхүүнийг ч анхаарах ёстой. Зорилтот дүүргүүдийн судалгаанд хамрагдах хүмүүс болон ганцаарчилсан ярилцлагад оролцох хүмүүсийг сонгоход хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс/хүүхдүүд, хотын зах болон төвийн оршин суугчдын харьцааг харгалзан үзэх шаардлагатай.

Төслийн менежмент

Тендерт оролцогч нь судалгааны зохион байгуулалтын ажлын талаар ЯХИС-ийн төслийн багтай хэлэлцэнэ.

- Гүйцэтгэгч нь үрт болон богино хугацааны судлаачдыг сонгох, төлөвлөх, бэлтгэх, удирдах, сургах, үүрэг даалгавар өгөх хариуцлага хүлээнэ.

- Гүйцэтгэгч нь хэрэгцээт тоног төхөөрөмж, хэрэглээний материалуудаар хангах, үйл ажиллагааны болон захиргааны зардлыг хариуцна.
- Гүйцэтгэгч нь санхүүгийн бүхий л зардал, зарлага, нэхэмжлэлийг ЯХИС-ийн журам, шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээний ерөнхий нөхцөлийн дагуу ЯХИС-аас шаардах тайлангаас гадна дараах тайланг ирүүлнэ. Үүнд:

- Эхлэлийн тайлан - Гүйцэтгэгч нь гүйцэтгэх ажлын төлөвлөгөө мөн судалгаанд оролцож буй судлаачдын хийх ажлын жагсаалтыг гаргаж өгнө. Төлөвлөгөө нь хуваарьт заасан ажил, үүрэг (үргэлжлэх хугацаа, судалгаа хийх өдрүүд) байршлын талаарх мэдээллийг багтаасан байна.
- Үнэлгээний тайлан – Гүйцэтгэгч нь төслийн үр дүнгийн үнэлгээний зорилго, арга зүй, арга зүйн давуу болон сул талууд, дүн шинжилгээ, дүгнэлт, зөвлөмжийг тусгасан эцсийн тайланг ирүүлэх үүрэгтэй.

4. Судалгааны багийн бүрэлдэхүүн

Тендерт оролцогч нь CV буюу намтарт үндэслэн (7-р хэсгийг харна уу) судалгааны багийн гишүүдийн гүйцэтгэх ажил үүрэг, тавигдах шаардлагад нийцэх үр чадвар, туршлага бүхий судлаачдыг сонгон баг бүрдүүлнэ. Хүйсийн тэгш байдлыг хадгалсан баг бүрдүүлэх нь давуу тал болно. Судалгааны багийн гишүүд тус бүрд тавигдах шаардлага, үр чадварыг доор тусгасан бөгөөд энэ нь судалгааны багийн гишүүдийн нийт тоонд хамааралгүй болно.

Судалгааны багийн ахлагч

Багийн ахлагчийн үүрэг:

- Гэрээлэгч талаас зөвлөх үйлчилгээний ажлын үүрэг хариуцлагыг хүлээх (гэрээний заасан хугацаанд, чанартай гүйцэтгэх)
- ЯХИС, хамтрагч болон төсөлд оролцогч талуудтай холбоо харилцааны ажлыг хариуцаж, зохицуулах
- Судлаачдыг ерөнхий удирдлагаар хангаж, төлөвлөх, үүрэг өгөх, дэмжин туслах
- Судалгааны явц, үйл ажиллагааны талаар гэрээнд заагдсан хугацаанд тогтмол тайлагнах
- Судалгааны чанарыг бүрэн хариуцах
- Судалгааны тайланг Хүүхдийг Ивээх Санд ирүүлэхээс өмнө хянаж эцэслэх

Судалгааны багийн ахлагчид тавигдах шаардлага:

- Боловсрол: Нийгэм болон судалгааны салбарт магистр, түүнээс дээш зэрэгтэй байх
- Хэлний мэдлэг: Англи хэлний өндөр мэдлэгтэй
- Мэргэжлийн туршлага: Нийгмийн эмпирик судалгаанд дүн шинжилгээ хийж, арга зүй, зохион байгуулалтын ажил хийж байсан 5 жилийн ажлын туршлагатай байх
- Ажлын туршлага: Судалгаа хийх гэрээний хугацаанд чанарын өндөр түвшинд ажлыг гүйцэтгэж, захиалагчийн хүсэлтийн дагуу өөрчлөлт хийх уян хатан чадвартай байх
- Удирдах үр чадвар, туршлага: Төслийн судалгаа, зөвлөх ажлын багийн удирдагчаар ажиллаж байсан 5 жилийн ажлын туршлагатай байх
- Орон нутагт ажиллаж байсан туршлага: Төрийн байгууллага, удирдлагуудтай ажиллаж байсан 3 жилийн туршлагатай байх
- Хөгжлийн хамтын ажиллагааны туршлага: Олон улсын болон соёлын ялгаатай багт ажиллаж байсан 3 жилийн ажлын туршлагатай байх, ОУБ-тай хамтарч ажиллаж байсан бол давуу тал болно.

Судлаач 1: Судалгааны менежер:

Судалгааны менежерийн үүрэг:

- Судалгааны ажлын арга зүй, зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө гаргах
- Судалгааны асуумж, ярилцлагын ерөнхий төлөвлөгөө гаргах
- Бэлтгэл ажил болон зохион байгуулалтын төлөвлөгөө хийх
- Орон нутгийн чиглүүлэгч багуудын ахлагчийг бэлтгэх

Судалгааны менежерт тавигдах шаардлага:

- Боловсрол: Нийгэм болон судалгааны салбарт магистр, түүнээс дээш зэрэгтэй байх
- Хэлний мэдлэг: Англи хэлний
- бичгийн болон ярианы ахисан түвшний мэдлэг, үр чадвартай
- Мэргэжлийн туршлага: Нийгмийн эмпирик судалгааны арга зүй, зохион байгуулалтын ажил хийж байсан 5 жилийн ажлын туршлагатай байх
- Ажлын туршлага: Нийгмийн эмпирик судалгаа хийж байсан ажлын туршлагатай байх
- Удирдах үр чадвар, туршлага: Нийгмийн эмпирик судалгааны менежер хийж байсан 5 жилийн ажлын туршлагатай байх
- Орон нутагт ажиллаж байсан туршлага: төрийн байгууллага, удирдлагуудтай ажиллаж байсан 3 жилийн ажлын туршлагатай
- Хөгжлийн хамтын ажиллагааны туршлага: Олон улсын болон соёлын ялгаатай багт ажиллаж байсан 3 жилийн ажлын туршлагатай байх, ОУБ-тай хамтарч ажиллаж байсан бол давуу тал болно.

Судлаач 2: Дата, мэдээлэл цуглуулах мэргэжилтэн:

Дата, мэдээлэл цуглуулах мэргэжилтний үүрэг:

- Дата, мэдээлэл цуглуулах ажлын зураглал гаргах
- Мэдээлэл алдагдахаас сэргийлэх, аюулгүй байдлыг хангах зураглал гаргах
- Дата, мэдээлэл оруулах, дүн шинжилгээ хийх
- Орон нутгийн чиглүүлэгчдийг дата мэдээлэл цуглуулах, оруулах, дата менежмент хийхэд сургах
- Мэдээллийг хамгаалах техникийн болон байгууллагын шалгуур, дүрэм журмыг баримтлах

Дата, мэдээлэл цуглуулах мэргэжилтэнд тавигдах шаардлага:

- Боловсрол: Нийгэм болон судалгааны салбарын Магистр зэрэгтэй (Мэдээллийн технологи болон ижил төстэй салбарт)
- Хэлний мэдлэг: Англи хэлний мэдлэгтэй
- Мэргэжлийн үр чадвар: Нийгмийн эмпирик судалгаануудад дата анализ, дата менежмент, чанарын баталгаа, дата мэдээлэл цуглуулах ажилд хяналт хийж байсан 5 жилийн ажлын туршлагатай
- Ажлын туршлага: Компьютерт ярилцлагын тэмдэглэл шууд бичих чадвартай, ажлыг чанартай гүйцэтгэдэг, дата мэдээлэл цуглуулах ажилд хяналт тавьж Excel эсвэл SPSS программ дээр мэдээлэл оруулах, процесс хийх чадвартай байх
- Удирдах үр чадвар, туршлага: Дата, мэдээллийн баг удирдаж байсан 5 жилийн ажлын туршлагатай байх
- Орон нутагт ажиллаж байсан туршлага: Монгол байгууллагатай мэдээлэл цуглуулж, анализ хийж байсан 3 жилийн ажлын туршлагатай байх

- Хамтын ажиллагааны туршлага: Олон улсын болон соёлын ялгаатай багт ажиллаж байсан ажлын туршлагатай байх

Богино-хугацааны судлаач 1: Орон нутагт нутагт мэдээлэл цуглуулах багийн ахлагч:

Орон нутагт мэдээлэл цуглуулах багийн ахлагчийн үүрэг:

- Орон нутагт мэдээлэл цуглуулах багуудыг ахлах, удирдах
- Орон нутагт мэдээлэл цуглуулах багийн гишүүдэд судалгааны зорилго, үйл явц, асуумж, оролцооны арга зүй, практик, ярилцлага хийх талаар танилцуулах
- Мэдээлэл цуглуулагчдыг судалгааны зорилго, арга зүй, мэдээлэл цуглуулах, асуумжаа туршиж үзэх, ярилцлага хийхэд дадлагажуулах, мэдээллээ оруулах зэрэгт сургах, бэлтгэл хангах
- Судалгаанд хувь хүний мэдээллийг хамгаалах

Орон нутагт мэдээлэл цуглуулах багийн ахлагчийн үр чадвар

- Боловсрол: Нийгмийн чиглэлийн Их сургуулийн бакалавр зэрэгтэй
- Хэлний мэдлэг: Англи хэлний ерөнхий мэдлэгтэй
- Мэргэжлийн туршлага: 2 жил нийгмийн эмпирик судалгаа хийж байсан туршлагатай байх
- Ажлын туршлагатай: Компьютерт ярилцлагын тэмдэглэл шууд бичих чадвартай, ажлыг чанартай гүйцэтгэдэг байх
- Удирдах үр чадвар: Судалгааны мэдээлэл цуглуулагчдыг ахлах, удирдах чадвартай байх
- Орон нутагт нийгмийн чиглэлийн эмпирик судалгаа хийж байсан туршлагатай байх

Богино хугацааны судлаач 2: Орон нутагт мэдээлэл цуглуулагчид

Орон нутагт мэдээлэл цуглуулагчийн үүрэг :

- Мэдээлэл цуглуулах
- Зааврын дагуу мэдээлэл боловсруулах

Шаардлагатай үр чадвар:

- Боловсрол: Их сургуулийн оюутан, төгсөгч (ШУ-ны бакалавр зэрэгтэй)
- Хэлний мэдлэг: Англи хэлний ерөнхий мэдлэгтэй
- Мэргэжлийн туршлага: 2 жил нийгмийн эмпирик судалгаа хийж байсан туршлагатай байх
- Ажлын туршлага: Нийгмийн эмпирик судалгаанд чиглүүлэгч хийж байсан туршлагатай байх
- Удирдах үр чадвартай байх
- Орон нутагт нийгмийн эмпирик судалгаа хийж байсан туршлагатай байх

Багийн гишүүдийн үр чадвар

Багийн гишүүд нь мэргэжлийн үр чадвараас гадна дараах чадваруудыг эзэмшсэн байх шаардлагатай

- Багаар ажиллах чадвартай
- Санаачилгатай
- Харилцааны үр чадвартай
- Нийгэм соёлын чадамжтай
- Жендерийн болон соёлын мэдрэмжтэй
- Үр дүнтэй хамтрагч, үйлчлүүлэгчид чиглэсэн арга барил эзэмшсэн
- Салбар хоорондын сэтгэлгээтэй

Багийн ахлагч нь богино хугацааны судлаачдынхаа үр чадварыг тодорхойлох шаардлагатай.

5. Төлбөр болон бусад холбогдох зардлууд

Гэрээ байгуулснаас хойш ажлын 5 өдөрт багтаж урьдчилгаа 50%-ийн төлбөрийг шилжүүлэх ба үлдэгдэл 50%-ийг судалгааны эцсийн тайланг ЯХИС чанарын шаардлага хангасан гэж үзэн хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан төлнө.

Гэрээлэгч нь судалгааг хийж гүйцэтгэхтэй холбоотой бүхий л зардлыг энэхүү төсөвт багтаан зохион байгуулна. Үүнд: оффис бичиг хэргийн зардал; техник хэрэгсэл, харилцаа холбооны зардал; судалгаа болон тайлантай холбоотой зардал; багийн гишүүд зорилтот дүүргүүдэд зорчих унаа болон томилолт, хоолны зардал; түүнчлэн ажлын удирдамжид дурдагдсан бусад бүх зардал орно.

6. Төслийн багийн удирдлага ба оролцоо:

Судалгааны турш ХИС-гийн зүгээс төслийн баг, хяналт, үнэлгээний ажилтан чиглэл өгч, дэмжин ажиллана. Судалгааны баг нь төслийн зохицуулагч болон хяналт үнэлгээний ажилтанд ажлын гүйцэтгэлийн тайлан, мэдээллийг тогтмол явуулна. Мөн орон нутагт судалгаа явуулахад тухайн орон нутгийн удирдлагууд, холбогдох албаны хүмүүстэй холбогдох зэргийг судалгааны баг хариуцах ба судлаачид нь судалгааны туршид өөрсдийн аюулгүй байдал, хувийн эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгал зэргийг хариуцна.

7. Сонгон шалгаруулалтад тавигдах шаардлага

Шаардлага хангасан судалгааны баг нь 10 хуудаснаас хэтрэхгүй судалгаанд оролцох хүсэлтээ илэрхийлсэн дараах баримт бичгүүдийг багтаасан ажлын саналыг ирүүлнэ. Үүнд:

- Судалгааны багийн судалгааг хийж гүйцэтгэх сонирхлыг илэрхийлсэн захидал.
- Судалгааны ажлын төлөвлөгөө (хугацаа, аргазүй, аргачлал, зохион байгуулалт зэрэг).
- Байгууллагын мэдээлэл (гэрчилгээ), багийн ахлагч болон, судалгааны багийн бусад гишүүдийн анкет, ажлын туршлагыг харуулсан мэдээллүүд.
- Судалгааны үнийн санал, төсөв (судалгааны аргазүй, төлөвлөгөөнд нийцсэн байна).

Дээр дурдсан баримт бичгүүдийг дугтуйнд хийж битүүмжлэн дараах байдлаар хаяглан ирүүлнэ.

ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН: **“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь”** төслийн үр дүнгийн үнэлгээ

Материал хүлээн авах эцсийн хугацаа: 2025 оны 06 дугаар сарын 27

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төв, 4-р давхар

Сонирхол бүхий байгууллага, багууд бүрдүүлэх материалыг битүүмжлэн, **2025 оны 06-р сарын 27-ны** өдрийн **17.00** цагаас өмнө дараах хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона Төв, 4-р давхар, Хүүхдийг Ивээх Сан. (Хүнсний 20-ын Мөнгөн завьяа дэлгүүрийн ард, 23 сургуулийн урд талд)

- **Лавлах утас:** +976-11-329365-117, +976-11-329371-117